



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК

**КАСК, НҮҮРЭВЧ, МАЛГАЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

**Тендерийн нэр: Каск, малгай, нүүрэвч
Тендерийн дугаар: ХА-049/2020**

Улаанбаатар хот - 2020 он

ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендерийн нэр: **Каск, малгай, нүүрэвч**
Тендерийн дугаар: **ХА-049/2020**

“УБЦТС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос : **“Каск, малгай, нүүрэвч”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 12 -ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 09 цаг 30 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:
Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо,
Чингисийн өргөн чөлөө-45.
УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот.
Хангамж үйлчилгээний алба
Утас: 342420 +157, Факс: 976-341852
Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.


- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.




Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ


ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. 2019 оны санхүүгийн тайлан ирүүлнэ 2. Ижил төстэй бараа нийлүүлсэн 2019 оны туршлагын мэдээлэл /гэрээгээр нийлүүлсэн барааны гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хуулбар ирүүлэх, гэрээний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгийн 80%-иас багагүй байх 3. Төсөвт өртөг 24,399,760 төгрөг 4. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендер нээсэн өдрийн байдлаар татвар, хураамж, төлбөрийг шалгах бөгөөд аливаа төлбөрийн өртэй байх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ 6. Үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу ирүүлэх 7. Шүүхийн тодорхойлолт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлнэ. 8. Гэрээний үнээр, захиалгын хугацаанд техникийн шаардлага хангасан хаяг хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ. 9. Каск, малгай, нүүрэвч, нүдний шилний олон улсын чанарын шаардлага хангасан тухай сертификат ирүүлнэ. 10. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. 11. Нийлүүлэгдсэн бараа нь шалгарсан загвараас өөр байх, шалгалт, туршилтаар техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд шаардлагад нийцсэн бараагаар сольж өгөхийг баталсан мэдэгдэл ирүүлнэ. 12. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг үнийн саналд хавсаргаж ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.

ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2020 оны 03 дугаар сарын сарын 12-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 09 цаг 30 минутад тендерийн нээлтийн өрөөнд нээнэ./УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/ Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 45. УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба Утас: 342420 +157, Факс: 976-341852 Цахим хаяг: www.tender.gov.mn</p>
ТӨӨЗ 2.3	<p>Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, баталгаажуулсан мэдэгдлийн хамт ирүүлнэ. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

Гурав. Каск, малгай, нүүрвчид тавигдах шаардлага

Д / Д	Материалын нэр	Техникийн үзүүлэлт	Зориулалт	Тайлбар
1	<p>Дуулга малгай /каска/</p> 	<p>MNS 5621:2006, ISO EN397, ISO EN50365 стандартын шаардлагыг хангасан байна.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Дуулгын их бие:полиэтилен болон полипропилен (polypropylene, polyethelene) гм хатуу материалаар хийгдсэн байна. 2.Толгойн оройноос хөндийрүүлэх татуурга: 3ш байх ба дуулганд 6 цэгээр холбогдоно. 3.Дуулганы бүч нь чихний 2 талаар орж Эрүүвчлэгддэг, урт богиныг тохируулах тохиргоотой. 4. Салган сольж болдог хөлс шингээгчтэй. 5.Толгойд бэхлэгдэх хэсгээрээ хэмжээг тохируулах тохируулгатай байна. 6.Толгойны гадаргуутай харьцах хэсэг нь арьс цочроох, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. 7.Каскны ар болон хажуу талаас харагдахаар гэрэл ойлгогчтой байна. (тус бүрдээ 55мм эсвэл 5 см дөрвөлжин буюу туузан) 8. Малгайны размер 53-63 см, өвлийн цагт дотуур нь нимгэн ноосон малгай өмсөх боломжтой. 9.Механик үйлчлэлээс хамгаалах чадвар: 5 кг-ийн хагас бөмбөрцөг хэлбэртэй ачааг 1 м өндрөөс унагаж туршсан байна. 10.Цахилгаан гүйдлээс хамгаалах чадвар 1000В хүртэл 11.Температурын горим: -40°C-:+50°C Шар, цагаан, улаан өнгөтэй /тоо ширхэгийг захиалгаас харна уу/. 	<p>Өндрийн түвшин өөрчлөгддөг ажилд дээрээс унах биет, хөдөлгөөнтэй биетийн хүчтэй цохилтоос толгойг хамгаалах зориулалттай. Толгойг механик, дулааны, цахилгааны үйлчлэлээс давхар хамгаална.</p>	<p>Нэгээс доошгүй агаар сэлгэлттэй байвал сайн. “УБЦТС” ТӨХК-ийн логот малгайны гадна, духны хэсэгт байрлуулсан байна. Толгой хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл гурав хоорондоо тохирсон байна.</p>

2	 <p>Дотроо хамгаалалтын хатуулгатай саравчтай малгай /хамгаалалттай малгай буюу бамбай малгай</p> 	<p>ISO EN812 стандартын шаардлагыг хангана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Малгайны гадар материал:хөвөн даавvv 80%, полиэстер 20% байна. Хөдөлгөөнгүй нөлөөлөлд тэсвэртэй ABS хуванцар бүрхүүлэн дотор хамгаалалтын /бактери, мөөгөнцөр, хөгцөөс хамгаалах, доргилт шингээх зориулалттай зөөлөвч дэвсгэртэй байж болно/ хатуулгатай. 2. Малгайны гадар болон дотор хэсэг агаар орох боломжтой, агаарыг маш сайн сэлгэдэг /чийг татахгүй, хөлөргөхгүй/ байна. 3. Толгойны гадаргуутай харьцах хэсэг нь арс цочроох, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. 4. Малгайны чангалах, суллах тохиргоо нь дагзны хэсэгт байрлалтай, давхар түгжээтэй. 5. Хамгаалалтын хатуулга нь малгайнаас салдаг арчиж цэвэрлэх боломжтой, малгайны гадрыг угааж цэвэрлэх боломжтой. 6. Малгайны ар болон хажуу талаас харагдахаар гэрэл ойлгогчтой /цацруулагчтай/ байна. 7. Малгайны размер 53-63 см, жин нь 135 граммаас ихгүй, өвлийн цагт дотуур нь нимгэн ноосон малгай өмсөх боломжтой. 8. Хөнгөн цохилт /дунджаар 5кН хүчний үйлчлэл/-ыг тэсвэрлэх 9. Температурын горим: -30°C-:- +30°C <p>Хар хөх өнгөтэй.</p>	<p>Өндрийн түвшин өөрчлөгдөхгүй, хөдөлгөөний нягтрал ихтэй ажлын байранд хөдөлгөөнгүй биетийг хавирч шүргэх болон хөнгөн цохилтоос толгойг хамгаална.</p>	<p>“УБЦТС” ТӨХК-ийн логог малгайны гадна, духны хэсэгт байрлуулсан байна. Малгайны техникийн бичиг баримт, дагалдах сертификат эрх бүхий байгууллагаар баталгаажсан байна.</p>
3	<p>Цахилгаан нумнаас хамгаалсан нүүрэвч</p> 	<p>ISO EN166 стандартын шаардлагыг хангасан байна.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Нүүрэвчний харааны зэрэг: 1 буюу хараанд өөрчлөлт өгөхгүй байх 2.Зурагдах, зүсэгдэхээс хамгаалагдсан байна. 3.Линзний зузаан 1,2мм-ээс багагүй байна. 4.Нүүрэвчний материал: поликарбонатаар хийгдсэн байна. 5.Нүүрэвчний өндөр нь 240мм-ээс багагүй байна. 6.Дуулганд бэхлэх боломжтой, дуулганд бэхлэгдэхдээ нумарсан байдлаар бэхлэгдэнэ. 7.Ультра ягаан туяаны шүүлтүүртэй /зэрэглэл 3/, гэрэл шүүх чадвар /зэрэглэл 1,2/ химийн бодис / зэрэглэл 3/ болон цахилгаан нумнаас хамгаалсан /зэрэглэл 8/ 35кВ хүртэл 8. Металл хийц ороогүй. 	<p>Цахилгаан тоноглолд сэлгэн залгалт хийх үед нүүрийг хамгаална.</p>	<p>Нүүрэвчний техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, нүүрэвч гурав хоорондоо тохирсон байна.</p>

4	<p>Нүдний хамгаалах шилний техникийн тодорхойлолт</p> 	<p>MNS5389:2004 стандартад нийцсэн байна.</p> <p>1.Нүдний шил нь хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалан бууралтгүй, тунгалаг /салхины хүч12-190м/с.</p> <p>2.Нүдний шил нь өнгө үзэмжтэй, хөнгөн, арьсанд харшил өгөхгүй PVCполиамид, полиэтилен материалаар хийсэн байна</p> <p>3.Нүдний шил нь хэрэглэхэд хялбар, эвдэрсэн эд ангийг сольж засварлах бүрэн боломжтой байна. Нүдэнд орж болзошгүй механик биет болон хурц гэрлээс хамгаалах онцлогоос хамааруулан шилний зузаан 1мм-ээс 4мм хүртэл байна.</p> <p>4. Ажиллах орчноос шалтгаалан нүдний шилийг дуулганд угсарч, хэрэглэнэ. Техникийн үзүүлэлт , бүтэц салхины хүчийг тэсвэрлэх чадвараар нь:</p> <p>Сайжруулсан ---- S / 12м/с / зэрэглэлтэй</p> <p>5.Зориулалтаар нь:</p> <p>Гадны биет -----4 Хий болон тоос, шороо----5 Цахилгаан нум-----8 зэрэглэлтэй байна.</p>	<p>Нүдний шил нь хэрэглэхэд хялбар, эвдэрсэн эд ангийг сольж засварлах бүрэн боломжтой байна. Нүдэнд орж болзошгүй механик биет болон хурц гэрлээс хамгаалах.</p>	<p>Ашиглалт болон аюулгүй ажиллагааны зааврыг монгол хэл дээр дагалдуулж өгөх</p>
---	---	--	---	---

Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө бараа тус бүрээс 1ширхэг загвар ирүүлэх бөгөөд загвар ирүүлээгүй тендерээс татгалзана.

Нийлүүлэгдэх барааны хувьд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалт хангаж байгаа эсэхийг техникийн үзүүлэлт бүрээр нотолсон үйлдвэрийн баримт /техникийн өгөгдөл буюу паспорт/, холбоо барих хаяг, майл хаягыг заавал ирүүлнэ.

Захиалагч тендерт шалгарсан оролцогчийн нийлүүлэх барааг хүлээн авахдаа холбогдох бичиг баримттай тулгаж шалгана. Шаардлагатай тохиолдолд шинжилгээнд хамруулж, түүний дүгнэлтийг үндэслэн хүлээн авах шийдвэрийг гаргана.

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

	Нэр	Тодорхойлолт, тайлбар	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	1000В Цахилгаан нумын үйлчлэлээс хамгаалах нгүүрөвч	/PSF BSEN166.39-B	55	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	45 хоногт	
2	Дотроо хамгаалалттай саравчтай малгай	Техникийн шаардлага харах	552	ш	УБЦТС ТӨХК-ийн нисэх дэх агуулах	Гэрээ байгуулсан өдөр	45 хоногт	
3	Каск хамгаалалтын дуулга /цагаан/	Техникийн шаардлага харах	93	ш	УБЦТС ТӨХК-ийн нисэх дэх агуулах	Гэрээ байгуулсан өдөр	45 хоногт	
4	Каск хамгаалалтын дуулга /шар/	Техникийн шаардлага харах	276	ш	УБЦТС ТӨХК-ийн нисэх дэх агуулах	Гэрээ байгуулсан өдөр	45 хоногт	
5	Нүд хамгаалах шил		72	ш	УБЦТС ТӨХК-ийн нисэх дэх агуулах	Гэрээ байгуулсан өдөр	45 хоногт	
	Нийт		1048					

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **95** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээ дүгнэсэн акт зэрэг гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ 9.1. Алданги оногдуулах хувь: **хоногт гэрээний үнийн дүнгийн 0,1 %**
- Алдангийн нийт дүн: **гэрээний үнийн дүнгийн 10%**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]